

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.12.27, №12 (129)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№509

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Салаа замын ҮҮЛЗВАРТ



НИЙТЛЭЛ

Б.Булганчимэг
Хөгжлийн бодлогын магистр
ба одоо хөгжлийн салбарт
ажиллаж байна

Үндэстэн нийтээрээ
унавал нэг хүн тиг унаа

СЭРГЭВЭЛ НЭГ ХҮН ШИГ СЭРГЭЭ

III НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД
ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗ
ОЛГОХГҮЙ

➤ СОНГУУЛИЙН ХУУЛЬ
БАТЛАГДЛАА

➤ ХӨРӨНГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ЭРГЭН
ТОЙРОНД

VI НҮҮРТ

Салаа замын ҮҮЛЗВАРТ



2020 он гарахад долоохон хоног үлдлээ. Шинэ онд Ардчилсан хувьсгалын 30 жилийн ой тохионо. Гучин жил явсаар Монгол улс маань салаа замын уулзвар дээр ирээд байна. Яг одоо бид улс төрийн хувьд хуулиар засаглах уу, эсвэл хуулийг ашигласан улс төрчдийн гар дор амьдрах уу; эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй үлдэх үү, эсвэл Эрдэнэбилэгизмийг үргэлжлүүлэх үү; нийслэлийн иргэдийн хувьд утаатай цементэн ширэнгэд амьдрах уу, эсвэл эрүүл, ногоон орчинд аж төрөх үү гэдгээ шийдэх гэж байна. Бас сонгуулийн жил...

ХУУЛИЙГ ХУВЬДАА АШИГЛАХ УУ, ЭСВЭЛ ХУУЛИАР ЗАСАГЛАХ УУ?

Монгол улс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага ФАТФ (FATF) -ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)-ын өнгөрсөн 9-р сард Бангкокд болсон хуралд оролцож төр засгийн чадвартаа дүн тавиулав. ФАТФ-ийн 20 зөвлөмжөөс 15-ыг нь хэрэгжүүлж, үр дүнгийн үнэлгээний 11 үзүүлэлтээс 4-ийг нь биелүүлээгүй учир Монгол улс “дунд” авч, “саарал жагсаалтад” хоёр дахь удаагаа орлоо. Саарал жагсаалтын буруутныг хайсаар Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголбанкны удирдлагаар “туг тахив”. Яагаад Монгол улс саарал жагсаалтад орсон, яаж түүнээс гарах тухай цуврал гурван нийтлэлээс маань уншина уу.



▶ УИХ удаан хэлэлцсээр Үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт саяхан орууллаа. Энэ өөрчлөлт ямар үр дүн дагуулахыг цаг хугацаа харуулна. Гол нь засаглалын хамгийн том асуудал дагуулсан, хагас-ерөнхийлөгчийн “Монголчилсон” тогтолцоогоо өөрчилж чадсангүй. Шүүх засаглалын хүрээний өөрчлөлт нь бие даасан шүүхийг байгуулахад нэг алхам болсон гэж найдаж байна. Гэхдээ ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийг дагаж бусад хуулийг яаж засахаас

олон зүйл хамаарна. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудлаар бид цуврал дефакто мэтгэлцээн зохион байгуулсныг эндээс сонирхож болно.

2019 он бол шүүх засаглал улс төрөөс, тэр дундаа Ерөнхийлөгчөөс хэрхэн хараат болсныг баталсан жил байлаа. Ерөнхийлөгч 6-р сард Салхитын мөнгөний ордтой холбоотой 17 шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн боловч одоо болтол нөхөн томилоогүйн улмаас шүүх засаглал, түүний дундаас

дээд шүүхийн иргэний танхимын үйл ажиллагаа зогсоод байна.

Мөн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн шийдвэрээр шүүгч, прокурор, АТГ-ын удирдлагыг сольж болдог хууль баталснаар гүйцэтгэх эрх мэдэл нь шүүх эрх мэдэл рүүгээ халдсан муу жишиг тогтлоо. Хуулиар засаглах зарчим хэзээ хэрэгжихийг иргэд хүсэн хүлээсээр сууна. Хуулийн засаглалаа хэрэгжүүлж чадахгүй бол Ерөнхийлөгчийг өөрийг нь эгүүлэн татах асуудлыг 2020 онд босгох уу?

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ЮУ, ЭСВЭЛ ЭРДЭНЭБИЛЭГИЗМ ҮҮ?

Сүүлийн зуун жилд монголын эдийн засагт үнэмлэхүй өөрчлөлт оруулсан хоёр том төсөл бий. Эхнийх нь социализмын үед эхлүүлсэн зэс баяжуулах Эрдэнэт үйлдвэр. Энэ үйлдвэр манай улс төр, эдийн засгийн амьдралын хамгийн гол, ил далд тэтгэгч болж ирсэн билээ. Тийм учраас байгуулагдсанаасаа хойш нийгмийн амьдралын гол сэдвүүдийн нэг болсон. 2019 онд ч бас, Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийн маргаан хамгийн чухал сэдэв байлаа. Энэ хувьтай холбоотой хэргээр Худалдаа Хөгжлийн Банкны ТУЗ-ийн дарга Д.Эрдэнэбилэгийг баривчлаад, суллав. Энэ “спорт загасчлалын” учир начин одоо болтол тодорхойгүй үлджээ. Баривчилсан үеэр нь төр засаг Эрдэнэт үйлдвэрт онцгой байдал зарлаж хяналт, шалгалт хийсээр байна. Нийтийн мөнгөөр нийтийн хөрөнгийг төр засгийн удирдлагатай хуйвалдан завшсан энэ хэргийн тухай “Эрдэнэбилэгизм II” гэх нийтлэлээс маань уншаарай. Энэ үйл явдал нь монголын улс төр, эдийн засгийн өнөөгийн бодит дүр төрхийг бүрэн

илтгэсээр байна.

Дараагийнх нь шинэ зуунтай уралдан нээсэн Оюу толгой төсөл. Монголын эдийн засгийн хамгийн том энэ төслийг эхлүүлэх гэрээг байгуулсны 10 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ төслийг эхэлснээс хойш гэрээг байгуулсан, хэрэгжүүлснийг нь тойрсон олон асуудал яригдаж ирлээ. Монголын шүүх “Дубайн” гэрээг байгуулах төрийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзэв. УИХ нь “Оюу толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” тогтоол батлав. Ямар ч гэсэн 2020 онд Оюу толгойнд гэрээнд өөрчлөлт хийх нь гарцаагүй боллоо. Энэ гэрээнд нь ямар алдаа байгаа эсэх талаар эндээс уншаарай. Гэрээнд бид ямар, сайн өөрчлөлт оруулж чадах нь эргэлзээтэй. Учир нь ийм том хэмжээний гэрээ, хэлцэл дээр ажиллах мэргэжилтнүүдээ бид одоог хүртэл бэлтгээгүй байна. 2020 онд Оюу толгой төсөл гацах уу, урагшлах уу гэхтэй хамт гадаадын хөрөнгө оруулалт хаашаа эргэх асуудал шийдэгдэх юм.

ЦЭВЭР АГААР УУ, ЭСВЭЛ УТААТ ЦЕМЕНТЭН ШИРЭНГЭ ҮҮ?

У.Хүрэлсүхийн Засгийн газар УБ хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Оронд нь сайжруулсан шахмал түлшийг гэр хорооллын иргэдэд нийлүүлж эхлэв. Энэ шийдвэрийн үр дүнд нийслэлийн хорт утаа багассан нь хонгилын үзүүрт гэрэл харагдуулав. Харагдах хэсэг нь илт буурсан ч, агаар дахь тоосонцор, хүхэрлэг хийн хэмжээг бууруулах ажил үлджээ байна.

НҮБ-ын 2019 оны судалгаагаар агаарын бохирдол нь монголчуудын нас баралтын 10 гол шалтгааны нэг болсон. Агаарын бохирдлыг бууруулахад нийтдээ 4.1 тэрбум доллар шаардлагатай ч, 80 хувь нь хаанаас гарах нь тодорхойгүй ажээ. Хөрөнгө оруулалт хэд ч байсан “Цэвэр агаар сан” шиг саалгуулахгүй байхад л анхаарах шаардлагатай.

2019 оныг тодорхойлсон нэгэн үйлдэл бол Байгалийн түүхийн музейн барилгыг нураасан явдал байлаа. Нийслэлийн иргэд янз бүрийн хэлбэрээр тэмцсэн ч, хүчин мөхөстлөө. Түүх, соёлын нэгэн өв арчигдаж, оронд нь “цементэн ширэнгэний” тоо нэгээр нэмэгдэхээс болгоомжилж иргэд тэмцсэн юм. Бас нөгөө л газрын наймаа цаана нь байх эрсдэлтэй гэж зарим нь үзэж байна. Нийслэлийн газар ямар замаар ордгийг “Учиртай гурван хулгай” нийтлэлдээ бичсэнийг та санаж байгаа биз ээ. Үнэндээ Улаанбаатар хотын бараг барилга бүхэн “авлигын түүхэн хөшөө” юм. Одоо Байгалийн түүхийн музейн газар дээр дараагийн хөшөө босохыг харах бололтой.



Б.Булганчимэг

Хөгжлийн бодлогын магистр
ба одоо хөгжлийн салбарт
ажиллаж байна



Үндэстэн нийтээрээ унавал нэг хүн шиг уная

СЭРГЭВЭЛ НЭГ ХҮН ШИГ СЭРГЭЭ

АНУ-ын 44 дэх Ерөнхийлөгч Барак Обамаг шижигнэсэн залуу нэр дэвшигч байх 2009 оны намар би АНУ-д оюутан байж таарсан юм. Олон улсын харилцаа, улс төр судлалын ангийн оюутан байсан болохоор бараг авч байгаа хичээл бүр дээр түүний тухай яриа өрнөж, нэг удаа түүнийг Индианаполист ирэхэд анх удаа хэдэн мянган хүнтэй зэрэгцэн амьдаар нь яриаг нь сонсож билээ.

Америкийн угсаа гарал, яс үндэс өөр түмэн олныг тараан бутаргах биш нэгдэн нийлүүлнэ гэсэн уриагаараа тэр олонхын дэмжлэгийг хүлээж байлаа.

Дараа нь түүний ялалт байгуулсан түүхэн явдлыг 11-р сарын шөнө бусад гадаад оюутнуудын хамт гэрчилж, хөөрч, доргиж сууснаа санаж байна. Тэр хөөрсөн эрчээрээ түүний ялалтын тангаргийг монгол хэл рүү орчуулж сошиал хуудсандаа тавьж байснаас “Мэйн Стрийт зовж шаналж байхад Волл Стрийт баяжин дэвшиж байх утгагүй. Энэ улсад бид үндэстэн нийтээрээ унавал нэг хүн шиг уная, сэргэвэл нэг хүн шиг сэргээ. Урт удаан хугацааны туршидулс төрийг дотроос нь ялзруулж байсан хуваагдалт, өчүүхэн богино хараа, болчимгүй сэтгэлгээнд буцаж орохоос татгалзая” гэдэг мөрт нь сэтгэлд хоногшин үлджээ.

2009 оны тэр өвөл Обама бид 2 хоёулаа ДиСи рүү нүүж таарав. Мэдээж өөр, өөрийн ертөнцдөө. Барак Обама дэлхийн хамгийн том ардчилсан гүрнийг тэргүүлэхээр Цагаан ордон руу, би Эмнести Интернэшнл олон улсын хүний эрхийн байгууллагад дадлага хийхээр улбар шар метроны шугамны нэг захаас нөгөө зах руу өдөр бүр ирж буцдаг болов. Нэгдүгээр сарын жавар тачигнасан өглөө хар үүрээр эртлэн босоод хүмүүсийн эцэс төгсгөлгүй түрлэгийг даган Барак Обамагийн тангараг өргөх ёслолыг Пенсилваниагийн өргөн чөлөөнд харж зогссоноо санаж байна. Хоёрын хоёр дайн, аюул заналхийлсэн эх дэлхий, зуунд тохиосон хамгийн хохиролтой эдийн засгийн хямралын үеэр Барак Обама Ерөнхийлөгчийн албыг хүлээж авч байлаа. Миний дадлагын ажлын үндсэн хэсэг



нь жагсаал, цуглаан зохион байгуулалтад туслах, уриа лоозонгийн бэлтгэл ажлыг хангах, гишүүнчлэл, сайн дурынхныг хариуцах байв. Бидний хамгийн эхний ажил Обама Ерөнхийлөгчөөр хүний эрхийг уландаа гишгэж, дайны хоригдлуудыг яргалан шүүдэг Гуантанамогийн шоронг хаалгах тухай байсныг санаж байна. Энэ бүгдээс хойш 10 жилийн дараа надад нэгэн захидал ирсэн нь Обама гэх нэрээр хаяглагдсан сангаас Ази, номхон далайн бүсийн манлайлагчдын нэгээр шалгарсан тул 2019 оны 12-р сарын 10-нд Малайзын Куала Лумпур хотод бэлэн байхыг сануулан, урьсан захидал байлаа. Энэ хөтөлбөрт би зун хүсэлт явуулаад мартаж орхисон болохоор маш хурдан ажлаа цэгцэлж, амралт хүсэн, бэлтгэлээ базааж эхлэв. Барак Обама Ерөнхийлөгчийн албанаас буухдаа энэ дэлхийд, түүхэнд ямар зам мөр үлдээж байгаагаа

эргэцүүлэн дүгнэж байгаад тухайн үеийн өөрийн туслах одоо бол Обама сангийн гүйцэтгэх захирал Девид Симастаа тив, тивийн өөрчлөлт хийх гэж хичээн яваа, эрмэлзэл бүхий залуусыг олж нэгтгэмээр байгаагаа хуваалцсан нь явсаар энэхүү Обама манлайлагч хэмээх санаачилга болжээ. Африк тивээс эхэлсэн энэ хөтөлбөр энэ удаа Азийн 200 залуусыг нэгэн дээвэр дор цуглуулж, бие биедээ дэмтэй, хийрхэлгүй, төлөв манлайлал, бодит үр дүнг авчирдаг нинжин манлайлагчид болгон зарлаж байгаагийн нэгэнд миний бие азаар багтсан хэрэг юм байна.

Миний дурдсан эдгээр үгс бол үнэхээр энэ хөтөлбөрийн 5 өдрийн туршид чихэнд байнга хангинаастай байсан үгс билээ. Хөтөлбөрийн хувьд өглөө эрт босоод 200 залуус маань нэгэн том танхимд цуглаж хэн нэгэн өндөр түвшний зочидтой тодорхой сэдвийн дагуу хэлэлцүүлэгт орсноор эхэлнэ. Сэдвийн хувьд Ази тивийн шинэ сорилтууд, боломжууд, зорилго бүхий бизнес, ёс зүйт манлайлал гэх

зэрэг хэлэлцүүлгүүд байсан бөгөөд Уур амьсгалын ногоон сангийн захирал С.Оюун, Эйр Эжиа группын үүсгэн байгуулагч тэрбумтан Тони Фернандез зэрэг Ази тивийн томоохон илтгэгчид оролцсон юм. Нэгдсэн хэлэлцүүлгийн дараа бид өртөөчилсөн жижиг сургалтуудад хуваагдан суудаг байлаа. Дэлхийд тэргүүлэгч Эделман, Сити зэрэг группээс тусгайлан уригдсан багш, сургагч нар бидэнд ёс зүйт манлайлал, чин сэтгэлээсээ бусдад хандах, хамтын зорилго, илтгэх чадвар, цаг хугацааг удирдах, хүчээ зөв зарцуулах, уур амьсгалын өөрчлөлт, хэвлэл мэдээлэлтэй харилцах зэрэг маш олон сургалтуудыг ганцаарчилсан эсвэл багийн хуваариар зааж байлаа. Түүнээс гадна орой бүр зохиогдсон танилцах үйл ажиллагааны хөгжилтэй, дурсамжтай байсныг ч онцлох нь зүй. Энэ хөтөлбөрийн хамгийн онцлог үйл явдал нь Ерөнхийлөгч Барак Обама, гэргий Мишель Обама болоод Холливудын алдарт жүжигчин Жулиа Робертс нар бидэн дээр ирж тус тусдаа хэлэлцүүлэг зохион байгуулсан нь байлаа.



Жулиа Робертс, Мишель Обама нар эмэгтэйчүүдийн манлайлал, төлөв, даруу боловч тууштай байж зорьсон хэргээ бүтээхийн тухай ярьсан бол ноён Барак Обама амьдрал, тэмцэл, зорилгоо зөв тодорхойлох, зорилгодоо хэрхэн хүрэхийн тухай маш энгийнээр, өөрийн түүхээрээ жишээ татан байж ярьсан нь сэтгэлд маш дотно үлджээ. Хамгийн сонирхолтой үйл ажиллагаа нь миний хувьд энэхүү 3 эрхмийн хамтаар сургуулийн хүүхдүүдэд хэрэгцээтэй байгаа ширээ сандлыг хийж өгсөн бичил төслийн өдөр байсан юм. Дэлхийн түүхийн хувь заяаг эргүүлж явсан, эргүүлж ч яваа энэ эрхэмтэй гар барьж, нэрээ, эх орноо, ямар ажил хийдгээ хэлж, хөтөлбөрийн сайн муугийн талаар сэтгэгдлээ хэлсэндээ тэгтлээ их баярлаж бас сандарч байгаа нь миний бяцхан эго ч юм болов уу, гэхдээ амьдралын тод нэг дурсамж болно гэдэгт итгэлтэй байна.

Бусад 199 оролцогчийн хувьд бүгдтэй нь танилцаж ярьж амжихгүй гэх нэг томоохон асуудал байсан ч уулзсан хүн бүр бодит манлайлагч, ямар нэгэн юм бүтээж, асуудал шийдэж чадсан залуус байсан нь намайг өөрийгөө голоход, явж байгаа зам мөрөө эргэж харахад хүргэж байсан нь надад өгсөн хамгийн том өгөөж байсан болов уу. Монголоос надтай хамт 3 өөр оролцогч байсан нь НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдлэгийн менежментийн ажилтан Б.Мөнгөнхишиг, Нээлттэй нийгэм сангийн засаглал хариуцсан менежер Д.Энхцэцэг, Уур амьсгалын ногоон сангийн ажилтан Д.Мөнхбат нар бөгөөд өөр, өөрийн салбартаа мэргэшсэн эдгээр залуустай хамт эх орноо төлөөлөн, хөтөлбөрөөс сурсан мэдсэнээ монголынхоо нөхцөлд яаж ашиглаж болохоо хором бүрт хуваалцан явах нь сайхан байлаа.

Зохион байгуулалтын хувьд маш өндөр зэрэглэлийн байснаас, бүх үйл ажиллагаа нь байгальд ээлтэй, нэг удаагийн хэрэглээнээс аль болох татгалзсан байсан нь гүн сэтгэгдэл төрүүлсэн билээ.

ИНГЭЭД БИ ЭНЭ ХӨТӨЛБӨРӨӨС ЯМАР СЭДЭЛТЭЙ БУЦАЖ ИРСНЭЭ ЖАГСААН ХУВААЛЦВАЛ:

- Бид алслагдсан, уулын ар дахь тосгоны бөглүү зах зээлтэй байгаа сул талаа хүлээн зөвшөөрч залуусаа аль болох тогоон доторх хэрүүлд эрч хүчээ зарцуулахаас илүүтэйгээр бүс нутгийн, олон улсын түвшинд сурч боловсорч, өрсөлдөж сураасай гэж хүсэхээр байна
- Аливаа үйл ажиллагааг байгальд ээлтэй, бүгдийг хамруулсан хэмжээнд зохион байгуулах соёлыг хэвшүүлмээр байна
- Үйл ажиллагаа зохион байгуулахдаа хэлбэр, агуулга бус өгөөжийг нь тооцож зохион байгуулах нь чухал гэдгийг анхаарах
- Орчин цагт хүчтэй, чадалтай манлайлагч байх нь хангалтгүй болжээ. Дэлхий даяараа төлөв, нинжин, жинхэнэ манлайлагч гэдэг ойлголтууд дээр маш онцгойлон анхаарч байна.

Ямар ч аргаар хамаагүй гарч ирээд үндэстэнг талцуулсан, хуваасан, нийгмийн аливаа нэг ялгаа, өөр байдал дээр дөрөөлөн турхирч, өөрийн хүслээ гүйцэлдүүлсэн манлайллыг бид олон улсад харж байна. Тиймээс дараа үеийн залуусыг тийм муйхар, явцуу биш жинхэнэ дотортой, алсын хараатай, хүний төлөө байж, өөрийн зөв мөн чанар ёс суртахуунаараа чиг барьж амьдардаг болохын чухлыг бид нэн онцгойлон анхаармаар байна.

2020 оны сонгууль дөхөж, айлын

хаалга тогшин гоё баглаатай сурталчилгааны хуудас эхнээсээ үзэгдэх боллоо. Залуус гараад ирээсэй гэх нийгмийн дэмжлэг, дуудлага байгааг бид мэднэ. Гэхдээ тэр залуусаасаа би “Чамд юугаар ч сольшгүй, ямар ч хувийн эрх ашигт гажихгүй ёс суртахуун бий юу, чи ядуу энгийн ардаасаа авахуулаад бүх ард түмний зовлонг өөрийн мэт мэдэрч, зүрх сэтгэлээрээ ажилдаа хандаж чадах уу, эсвэл чи ямар ч аргаар хамаагүй хүчтэй болж, хэн нэгний явцуу эрхийн төлөө ажиллах

гэж байгаа юу, өнөөгийн хожил чамд чухал уу, эсвэл нийгмээрээ ядруухан яваа ард түмнийхээ төлөө ажиллаж өөрийн амьдралын замаа зурж чадах уу?” гэх асуултуудыг асуух сэдэл энэ удаагийн хөтөлбөрийн дараа илүү хүчтэй төрж байна. Дан ганц бусдаас асуух биш өөртөө ч гэсэн энэ асуултуудыг тавьж, илүү бодит өөрчлөлтийн төлөө ажиллах ёстойгоо ойлгосон өдрүүд байлаа.

2019 оны 12-р сар





ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.12.22-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗ ОЛГОХГҮЙ

Энэ оны 8-р сарын 24-нд Засгийн газрын 320-р тогтоол гарсан. Энэ тогтоолоор ашигт малтмалын лиценз буюу тусгай зөвшөөрөлд шалгалт хийж, үр дүнг нь танилцуулахыг заасан. Улмаар 8-р сарын 30-аас эхлэн 3 сар гаруйн хугацаанд тусгай зөвшөөрлүүдийг нэг бүрчлэн шалгажээ. Ингээд 12-р сарын 18-ны өдөр Засгийн газар хуралдаж нэг жилийн хугацаанд ашигт малтмалын хайгуулын лиценз олгохгүй байх шийдвэр гаргалаа. Мөн сүүлийн 3 сарын хугацаанд 700 гаруй тусгай зөвшөөрлийг цуцалсан байна.

Уул уурхайн салбараас өөр гадаадын хөрөнгө оруулалт татах салбар гарч ирээгүй байгаа учраас энэ шийдвэр мэдээж гадаадын хөрөнгө оруулалтад нөлөөлнө. Мөн 2019 оны 11 сарын мэдээгээр Монгол улс нийт 7.1 тэрбум долларын экспорт хийсний 83 хувь буюу 5.8 тэрбум доллар нь уул уурхайн салбарт ногдож байна.

2019 оны 12-р сарын 16-ны байдлаар нийт 2805 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байна. Үүнээс 1139 нь хайгуулынх, 1666 нь ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Монгол улс нийт нутаг дэвсгэрийнхээ 4.7 хувьд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байгаа. Хайгуулын үйл ажиллагаа 3.7 хувь, ашиглалт 1 хувь.



Үзүүлэлт	Тоо	Хувь	Гектар	Хувь	Нийт нутаг дэвсгэрт эзлэх %
Нийт	2,805	100%	7,422,820.6	100	4.7%
Хайгуулын	1,139	40.6%	5,799,510.2	78.1	3.7%
Ашиглалтын	1,666	59.4%	1,623,310.5	21.9	1%

Уг 1666 ашиглалтын тусгай зөвшөөрлөөс

- алт 566 буюу нийт зөвшөөрлийн 34 хувь
- барилгын материалын 329 буюу нийт зөвшөөрлийн 20 хувь
- нүүрс 296 буюу нийт зөвшөөрлийн 17.7 хувь
- жонш 186, төмөр 77 гэх мэт тусгай зөвшөөрөл байна. Цаана нь цагаан тугалаг, давс, холимог металл, газрын ховор элементийн тусгай зөвшөөрөл цөөн тоогоор байна.

Хайгуулын лиценз олгохгүй байх хугацаандаа уул уурхайн салбарын тусгай зөвшөөрлийн нэгдсэн нэг мэдээллийн сан байгуулна гэж байгаа юм байна.

Өнөөдөр байгаа бүх мэдээллүүд хагас дутуу, хоорондоо зөрүүтэй байгаа.

Уул уурхайг хөгжүүлэх бодлого зөвхөн цаасан дээр л байгаа. Уул уурхайн хуулиндаа жил бүр өөрчлөлт оруулдаг. Бодлого тогтворгүй байгаа буюу эдийн засгийн хамгийн гол салбараа тун хариуцлагагүй удирдажирсэн. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, олборлох, байгаль орчноо нөхөн сэргээх, ашигт малтмалын үр өгөөжийг шударга хүртээх, эдийн засгаа төрөлжүүлэх зэрэгт нэлээн гажуудал бий болсон гэсэн үг. Монгол улсад энэ салбараас эхлэж авлига улам гүнзгийрч, баян ядуугийн ялгаа хурдан тэлэхэд нөлөө үзүүлсэн.

СОНГУУЛИЙН ХУУЛЬ БАТЛАГДЛАА

12-р сарын 20-ны өдөр УИХ Сонгуулийн тухай хуулийг цаг хугацаатай уралдан баталлаа. Учир нь хуулийн дагуу УИХ-ын ээлжит сонгууль болохоос 6 сарын өмнө Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулдаггүй.

Ер нь одоогийн эрх баригч нам буюу УИХ дахь МАН-ын гишүүд сонгогдсон цагаасаа хойш Сонгуулийн тухай хуулийг өөрчилнө гэдгээ мэдэгдсээр ирсэн. Өмнө нь Ерөнхийлөгчийн, УИХ-ын, ИТХ-ын сонгуулиуд тус тусдаа хуулиар зохицуулагддаг байсан. Гэтэл өмнөх УИХ-ын бүрэлдэхүүн мөн адил 2016 оны УИХ-ын сонгууль болохоос өмнө цаг хугацаатай уралдан хуулийг өөрчилж, Ерөнхийлөгчийн, УИХ-ын, ИТХ-ын

сонгуулийн 3 хуулийг нэгтгэж байсан түүхтэй. Ээлжит сонгууль бүрийн өмнө сонгуулийн хуулиа өөрчилдөг жишиг тогтоод удлаа. Төрийн эрхийг барьж байгаа нам өөртөө ашигтай сонгуулийн хэлбэрээ сонгоод, түүндээ тохирсон дүрмээ зохиогоод түүгээрээ тоглож байна гэсэн үг.

2020 оны сонгууль мажоритар тогтолцоогоор явагдах болсон буюу хүнээ харсан сонгууль болох гэж байна. Институтийн хувьд харна гэвэл пропорциональ тогтолцоог сонгох байсан. Улс төрийн намууд институтийн хувьд бэхжиж чадахгүй байгаагаа харуулсан шийдвэр боллоо.

Өөрчлөлт орсон зарим заалтууд

- | | | |
|---|--|--|
| <ul style="list-style-type: none"> ♦ Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдон, ял шийтгүүлсэн хүн нэр дэвших эрхгүй ♦ Сонгогчдын нэрсийн жагсаалт улс төрийн намуудад нээлттэй байна. Өмнө нь хаалттай байсан ба одоо намууд хэнтэй өрсөлдөхөө мэдэж авна гэсэн үг. ♦ Нэр дэвшигчид үнэмлэхийг нь гардуулсан өдрөөс сонгуулийн сурталчилгаа эхэлнэ ♦ Сонгуулийн хандивыг нэмэгдүүлж иргэн 5 сая, хуулийн этгээд 20 хүртэл сая төгрөгийн хандив өгөх эрхтэй болсон. Намын санхүүжилт болон сонгуулийн санхүүжилтийн эх үүсвэрийн харьцаа гэж байдаг. Дэлхийн жишгээр | <ul style="list-style-type: none"> бол гуравны 1 нь өөрсдөө, гуравны 1 нь төсвөөс, гуравны нэг нь хандиваас бүрддэг. ♦ Цахим орчинд бусдыг гүтгэх доромжлохыг хориглосон ♦ Улс төрийн намууд эвсэл байгуулж сонгуульд оролцож болно. Намуудын олонх эвслээс гарсан бол эвсэл тарсанд тооцно ♦ Төрийн жинхэнэ албан хаагч УИХ-ын сонгуульд нэр дэвших бол 2020 оны 1-р сарын 1-ээс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна. Үүнд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал, дэд захирал, дарга, дэд дарга нар чөлөөлөгдөх шаардлагагүй ♦ Сонгуулийн сурталчилгааны хоног 18 байсныг 22 болгосон. Шинээр гарч ирж | <ul style="list-style-type: none"> байгаа хүнд бол 22 өдөрт өөрийгөө Монгол улс даяар танилцуулах бол тийм амархан ажил биш. ♦ Саналын хуудас нэг ширхэг байна ♦ Сонгогч тухайн тойрог дахь мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг дугуйлна. Илүү эсвэл дутуу бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно ♦ Шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн жилийн 2-р сарын 1-ээс хойш хориглоно ♦ Мажоритар тогтолцоогоор сонгууль явуулахтай холбоотойгоор гадаад улс оронд амьдарч байгаа сонгогчдын саналыг авахгүй ♦ Сонгуультай холбоотой маргааныг тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ |
|---|--|--|

Өөр нэг зүйл нь Сонгуулийн хороог өөрчлөөгүй хэвээр нь үлдээчихлээ. Зүй нь бол Сонгуулийн хороог Сонгогчдын хороо болгох ёстой. Удирдлагаар нь хуучин намын дарга, цэрэг байсан нөхдүүдийг биш аль нэг улс төрийн намгүй, хүлээн зөвшөөрөгдсөн иргэдийг тавих ёстой.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 3-р сараас 5-р сарын хооронд УИД-т шалгалт оруулсан. УИД хувьцаат компани, Номин реалтор гэж хоёр компани хоорондоо түрээсийн гэрээ байгуулсан. Тэр гэрээ нь зах зээлийн ханшаас доогуур байгуулагддаг. Харин Номин реалтор нь цаашаа түрээслэгчдэдээ зах зээлийн ханшаар түрээслээд явдаг. Санхүүгийн зохицуулах хороо нь “УИД” ХК-ийн 45000 орчим жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудын “УИД” ХК-ийн барилгыг гаднах талбайн хамт бүхэлд нь “Номин реалтор” ХХК-д түрээсэлсэн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулж, компанид учруулсан 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулах, мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлээгүйн улмаас 2017 оны 4-р сараас 2018 оны 12-р сарыг дуустал хугацаанд компанид учруулсан 428.6 сая төгрөгийн хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудаар гаргуулахаар 2019 оны 11-р сарын 1-ний өдөр Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Санхүүгийн зохицуулах хорооны дарга нэхэмжлэл гаргасан.



СЗХ-ны Хяналт, шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн: “Хувьцаат компанийн мөн чанар алдагдсан. Ногдол ашиг тараахгүй, урт хугацаанд “Номин”-оос зээл авч, зээлийн хүүг орлогоосоо төлдөг хэмээдэг. Валютын зээлийг 2009 оноос хойш олгохыг хуулиар хориглосон. Гэтэл валютын зээл авч ханшийн эрсдэл үүсгэсэн тухай тогтоосон. Эдгээр нөхцлийг “УИД” ХК албаар бий болгоогүй бол 2016 онд 3.9 тэрбум, 2017 онд 2.4 тэрбум, 2018 онд 2.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах боломжтой байсан. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хүртээх боломжийг алдсан. Одоогийн байдлаар шүүх дээр холбогдох хариуцлага болон мөнгөн торгуулийн асуудлыг хэлэлцэж байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос тус компанид 13 чиглэлийн үүрэг даалгавар өгсөн.”

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

GOOGLE STORE



APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан
Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com